



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№33 /247/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.17

Цаг үе, үйл явдал

“МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ХҮН АМЫН ОЮУНЫ ДАРХЛААНЫ АСУУДАЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛЖ БАЙНА



Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас “Монгол Цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын хамтарч “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: Хүн амын оюуны дархлааны асуудал” эрдэм шинжилгээний бага хурлыг өнөөдөр Гадаад харилцааны яаманд зохион байгуулж байна.

Хуралд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, доктор, профессор Ц.Тогоо, Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, эрдэмтэн судлаачид оролцлоо.

Энэхүү эрдэм шинжилгээний бага хурлын зорилго нь Үндэсний аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал, түүний дотор Монголын ард түмний эх орноо хамгаалах уламжлалт сэтгэлгээний ой санамжийн талаар манай орны нэр хүнд бүхий эрдэмтэн, судлаачдын санаа бодлыг сонсох, шүүн хэлэлцэх, санал дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх, илтгэл тавьсан, үг хэлсэн хүмүүсийн санаа бодлыг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эргэлтэд оруулахад оршиж байгаа аж.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр хурлыг нээж хэлсэн үгэндээ “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” нэртэй нэгэн чухал баримт бичиг анх батлагдсанаас хойш 30 жил өнгөрчээ. Энэ хугацаанд Монгол төрийн Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого амжилттай хэрэгжиж, төрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдал улам бүр баталгаажиж, манай улсын олон улсын нэр хүнд тогтмол өссөөр байна. Монгол Улс гаднаас шууд заналхийлсэн аюул заналгүй, энх тайван орчин, олон улсын хүрээлэлд оршин тогтнож, хөгжин бэхжих боллоо.

Үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдлын бодлогыг улс орны хэмжээнд нэгтгэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизм бий болж, төр, нийгэм, хувь хүний аюулгүй байдал бүрэн дүүрэн хангагдлаа гэж хэлэх цаг бас хараахан болоогүй байна. Түүнчлэн, сүүлийн жилүүдэд Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин, дотоод нөхцөл байдал эрс, огцом өөрчлөлтүүд гарах болж, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх цоо шинэ хүчин зүйлс бий болсоор байна. Энэ бүхнийг харгалзан үзсэний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүнээс уг үзэл баримтлалын хэрэгжилтэд шинжлэх



ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгөх, тодотгон шинэчлэх шаардлага байгаа эсэхийг судлан тодорхойлох, тийм шаардлага байвал үндэслэлийг нь боловсруулахыг бидэнд даалгасан. Иймийн тул бидний өнөөдөр зохион байгуулж буй “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал: хүн амын оюуны дархлааны асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлаас гарах санал, дүгнэлтүүд нь бидэнд ихээхэн ач холбогдолтой байх болно” хэмээн онцолж байв.

Хурлын үндсэн илтгэлийг Шинжлэх ухааны академийн философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, ардын багш Б.Даш-Ёндон “Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэдийн ухамсарлалын үүрэг” сэдвээр хэлэлцүүлсэн бол доктор, профессор Д.Бум-Очир, “Мэдлэгийн колоничлол ба оюун санааны дархлаа”, доктор Э.Энхмаа “Үндэсний эв нэгдэл, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлэх нь”, Ж.Алтайбаатар “Монгол улс дахь шинэ шашнууд: үндэсний

аюулгүй байдалд тулгарч буй шинэ сорилт”, профессор бригадын генерал О.Үржин “Монгол улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт, шинэ сорилтууд”, профессор хошууч генерал Н.Жалбажав “Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс”, доктор, профессор Б.Галиндэв “Үндэсний аюулгүй байдал, нийгмийн ёс суртахууны хамаарал”, доктор Ж.Цогтсугар “Нийгмийн оюуны дархлааг хамгаалахад нейросайнс судлалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага” зэрэг хавсралт илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас дээрх сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, семинар зохион байгуулахаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлэг өрнүүлэх, телевизийн цуврал нэвтрүүлэг хийх, ард иргэдийн дунд санал асуулга явуулах зэрэг олон ажлыг хэрэгжүүлэх ажээ.

Түүхэнд энэ өдөр

1921 он

Д.Сүхбаатар зүүн
Хиагтын харуулаас,
4 Л.Дэмбэрэл Хиагтын
баруун харуул
болон Л.Сумьяа
бээсийн хошуунаас
цэрэг элсүүлэхээр
морджээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-29


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,861.00	2,864.0
EUR	3,240.0	3,255.0
CNY	450.00	451.00
RUB	37.40	38.20
JPY	24.73	24.85
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.02.17 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР
БАР САРЫН ЕСӨН
УЛААН МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:
Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.55-18.17

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал: Уул

Энэ өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Эрдэнийг гадагш өгөх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,270,545 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,171,826 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,015,670 31,0% 92,216 /2,8%/
--	---	---

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8157 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 109	ЭДГЭРСЭН 7931
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 416,057,035

Эдгэрсэн

Нийт: 338,806,009

Нас барсан

Нийт: 5,857,018

Цахим шууданд

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ АЖИЛЛАВ



хурандаа Б.Энх-Од эмнэлгийн өнөөгийн байдал, цаашдын үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийв. Үүний дараа Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг Австри Улсын урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төслийн хүрээний тоног төхөөрөмжүүдийн дээжийг гардуулан өгсөн бөгөөд эмнэлгийн бие бүрэлдэхүүнд зарим үүрэг чиглэл өгсөн юм.

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа нарын албаны хүмүүс өнөөдөр Цэргийн төв эмнэлэгт ажиллалаа.

Төрийн нарийн бичгийн даргыг тус эмнэлэгт хүрэлцэн очиход Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч



30 КМ-ИЙН ЯВГАН МАРШИЙН ХҮРЭЭНД...



төв-ҮБХИС-ийн сургалтын төв-Шар хадны эцэс-Ангийн байрлал гэсэн чиглэлд зохион байгуулсан бөгөөд энэ үеэр дайсны ашигтай газар орныг эзэлж авах ажиллагаа, шархадсан цэргийн алба хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, татан гаргах, хордсон газар орныг туулах зэрэг даалгавруудыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ офицер, ахлагч нартай хүн нэг бүрийн бэлтгэлийн болон шалгалтын буудлагыг явуулсан юм.

Зэвсэгт хүчний 089 дүгээр анги
Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг шалгах, мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэх, сургалт бэлтгэлийг эрчимжүүлэх зорилгоор тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг энэ сарын 12-ны өдөр зохион байгуулав.
Явган маршийг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн засвар хангалтын төв-

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн хэргийн сургалтын

Ахмад П.ТҮВШИНТӨГС



“ЭХ ОРОНЧ ЗАЛУУ” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



зэрэгцээ хүний хөгжлийн индекс, аз жаргалын индекс, боловсролын индекс, өрсөлдөх чадварын индекс, оюуны чадвар, гэр бүлээ хайрлан хамгаалах, үр хүүхдийнхээ хажууд муу зуршилгүй байх, үйлдлээрээ үлгэрлэн манлайлах зэрэг олон сонирхолтой агуулгыг багтаасан юм.

Түүнчлэн эх оронч үзэл хүмүүжилтэй болгох 5 дадал зуршлыг бий болгох уриалгыг нийт бие бүрэлдэхүүнд дэвшүүлсэн юм. Үүнд, хүүхдийн дэргэд хорт зуршилгүй байх, гэр бүлээ эрхэмлэн хайрлах, бусдын төлөө сэтгэлтэй байх, сайн дурын үйл ажиллагаанд оролцох, манлайлагч буюу зөв хандлагатай, хүчирхийлэл үйлддэггүй байх зэрэг ойлголтууд багтжээ.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги
Тус анги Баян-Өлгий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн тасралтгүй хамтран ажиллаж, алба хаагчдынхаа гэр бүлийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, хүүхдийн хүмүүжлийн харилцаанд дэмжлэг үзүүлэхийц

олон шинэлэг сургалтыг чанартай зохион байгуулсаар байна. Өнгөрсөн долоо хоногт болсон “Эх оронч залуу” сэдэвт сургалтыг Баян-Өлгий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Гарыш удирдан явуулсан бөгөөд Зэвсэгт хүчний алба хаагчдын ажлын онцлог, давуу болон сул талыг хөндөхийн



Монгол цэрэг энхийн үйлсэд

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ОРОЛЦОО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Сүүлийн жилүүдэд НҮБ-ын системийн бүх байгууллагад түүний дотор энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлаар НҮБ-ын аюулгүйн зөвлөл тусгайлан хэлэлцэж хэд хэдэн тогтоол, шийдвэрүүд гаргаад байна.

Анх 2000 онд НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар (Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал-woman peace and security) тогтоол батлагдсанаар

НҮБ-ын хүйсийн эрх тэгш байдлыг хангах амлалт нь албажсан төдийгүй эмэгтэйчүүдийг улс орныг удирдах, шийдвэр гаргах түвшинд ажиллуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр бодлого гарган хэрэгжүүлэх, энхийг сахиулах ажиллагаанд дахь эмэгтэйчүүдийн оролцоог тодорхой төлөвлөгөө, зорилготойгоор нэмэгдүүлэх чиглэлд онцгойлон анхаарал хандуулахыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад даалгасан байдаг.

Дээрх тогтоолоор НҮБ-ын гишүүн орнуудыг дараах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг уриалсан байдаг. Тухайлбал,

1. Аюулгүй байдал, энх тайвантай холбоотой бүх шатны шийдвэр гаргах үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцох боломжоор хангах;
2. Жендерийн талаарх ойлголтыг агуулсан энхийг сахиулах ажиллагааны сургалтын хөтөлбөр боловсруулах;
3. Жендерт суурилсан хүчирхийллээс, ялангуяа бэлгийн хүчирхийллээс хамгаалах;
4. НҮБ-ын энхийг сахиулах болон бусад хөтөлбөрүүдийн

хэрэгжилтийн тайланд жендерийн хэтийн төлөвийг тусгах.

НҮБ-ын ЕНБД-ын 2018 онд дэвшүүлсэн энхийг сахиулах үйл ажиллагаа санаачилгын хүрээнд энхийг сахиулах ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зэрэг багц асуудлаар анхаарч ажиллахад чиглэсэн бодлого, хөтөлбөр гарган ажиллахыг нарийн бичгийн дарга нарын газарт даалгасны зэрэгцээ НҮБ-ын салбар байгууллагуудад болон энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэмжээг тогтмол өсгөж ажиллахыг цэрэг хандивлагч орнуудад уриалж, 2028 он гэхэд цэргийн ажиглагч эмэгтэйчүүдийн тоог 25, цэргийн багт үүрэг гүйцэтгэх эмэгтэйчүүдийн 15, цагдаагийн эмэгтэйчүүдийн 30 хувь нийтдээ 5,6 хувийн өсөлт гарахаар төлөвлөсөн байна.

Дээрх тогтоолоос гадна НҮБ-ын аюулгүйн зөвлөлөөс гишүүн орнуудад хандсан 2242 (2015 он), 2538 (2020 он) дугаар тогтоолуудыг батлагдсан. Эдгээр тогтоолуудын агуулгыг авч үзвэл, эмэгтэйчүүдийг улс орныг удирдах, шийдвэр гаргах түвшинд ажиллуулах бодлого, хөтөлбөрөө дахин хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт хийхийг уриалж, ялангуяа олон улсын энх тайван, аюулгүй байдлын үйл хэрэг дэх эмэгтэйчүүдийн оролцоог үе шаттайгаар нэмэгдүүлэх, тулгарч буй саад, бэрхшээлийг судлан тогтоох, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, жил бүрийн өсөлтийг зорилтот хэмжээнд хүрсэн эсэхийг мэдээлж байх,



сайн туршлага, арга барилыг бусдад дэлгэрүүлэхэд анхаарч ажиллах, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог бүрдүүлэх, түүний дотор ЭСА-нд үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжоор хангах чиглэлээр үндэсний хэмжээний стратеги хэрэгжүүлж ажиллахыг уриалжээ. Монгол Улс нь НҮБ, түүний салбар байгууллагуудаас дэвшүүлсэн эмэгтэйчүүдийн олон улсын энх тайван, аюулгүй байдлын үйл хэрэгт оруулах хувь нэмрийн талаарх санаачилгыг эхнээс нь дэмжиж ирсэн бөгөөд энэ чиглэлд манай улс байнга хүчин чармайлт гарган ажиллаж байгаа талаар жил бүрийн Ерөнхий ассамблейн чуулганы хуралдаан дээр тэмдэглэж ирсэн байдаг.

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-аас эмэгтэйчүүдийн олон улсын энх тайван, аюулгүй байдлын хүрээнд тэгш оролцоог бүрдүүлэх, бодитой оролцоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг хэрэгжүүлж байна.



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штабт дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (p-3, p-4, p-5) сонгон шалгаруулалтад хамрагдах сонирхолтой офицеруудыг сонгон шалгаруулалтад урьж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн дарга p-5
- Бодлого, номлол хариуцсан ахлах офицер p-5
- Цэргийн асуудал хариуцсан ахлах офицер p-5
- Ахлах холбогч офицер p-5
- Цэргийн асуудал хариуцсан офицер p-4
- Төлөвлөлтийн офицер p-4 (бодлого төлөвлөлт)
- Төлөвлөлтийн офицер p-4 (хүч бүрдүүлэлт)
- Бодлого, номлол хариуцсан офицер p-4
- Дүн шинжилгээний офицер p-4
- Хуулийн офицер p-4
- Цэргийн зөвлөхийн орлогчийн тусгай туслах p-4
- Төлөвлөлтийн офицер p-3 (бодлого төлөвлөлт)
- Дүн шинжилгээний офицер p-3

Сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулах журам”-ыг судлан танилцаж, журмын 3.3, 3.6, НҮБ-ын штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт, тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг rsod@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС